mobicom

ДАРААТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МИНИЙ МОБИ БАГЦЫН НӨХЦӨЛ

/ Хувь хэрэглэгч /

НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

1.1 Багцын ерөнхий нөхцөл

1.1.1 Миний моби багцын хэрэглэгч Хавсралт 1.2-т заасан дараах хэрэглээний эрхүүдээс сонгон ашиглана.

1.1.1.1 Үүрэн холбооны ярианы эрх

1.1.1.2 Хөдөлгөөнт интернэт дата эрх

1.1.2 Хэрэглэгч ярианы эрх болон хөдөлгөөнт интернэт дата эрхийн аль нэгийг заавал сонгож Миний моби багцыг бүрдүүлнэ.

1.1.3 Сүлжээндээ хязгааргүй яриа болон 5GB дата эрхүүдийг дангаар сонгох боломжгүй. Харин 5GB дата эрхээс бусад дата болон сүлжээ харгалзахгүй хязгааргүй ярианы эрхийг дангаар сонгох боломжтой.

1.1.4 Хэрэглэгч ярианы эрхийг сонгоогүй, багцад дагалдах эрхээс гадуур хэрэглээ хийсэн бол Хавсралт 1.2-т заасан үнэ тариф тооцогдоно.

1.2 Шинэ дугаарт дагалдах нэмэлт үйлчилгээ

1.2.1 Шинэ дугаарын сим картыг гар утас болон төхөөрөмжид хийж идэвхжүүлэхэд дараах үйлчилгээнүүд нээлттэй байна.

1.2.1.1 Дата үйлчилгээ

1.2.1.2 Дуудлага хүлээлгэх, дуудлага барих, дуудлага шилжүүлэх нэмэлт үйлчилгээнүүд

1.2.1.3 Дугаар харах нэмэлт үйлчилгээ

1.3 Бүртгэлийн хураамж

1.3.1 Шинэ хэрэглэгч Хавсралт 2.1-т заасны дагуу бүртгэлийн хураамжийг төлнө.

1.4 Сарын хураамж

1.4.1 Сарын хураамж нь доорх нөхцөлүүдээс бусад тохиолдолд сар бүр нэхэмжлэгдэнэ. Үүнд:

1.4.1.1 Хэрэглэгч дугаар хадгалуулах үйлчилгээ авсан.

1.4.1.2 Хууль болон гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон.

1.4.2 Хэрэглэгч хэрэглээ хийсэн эсэхээс үл хамаарч сарын хураамж нь үйлчилгээний нөхцөлд заасны дагуу тогтмол нэхэмжлэгдэнэ.

1.4.3 Гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгчид 1.4.1 болон 1.4.2 заалтууд хамаарахгүй.

1.4.4 Шинэ хэрэглэгч сарын дундуур гэрээ байгуулсан тохиолдолд багцын сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн нэхэмжлэх бөгөөд багцаддагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

1.4.5 Төлбөр төлөөгүйн улмаас үйлчилгээний эрхээ хаалгасан дугаарын тухайн сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.

1.5 Багцад дагалдах хэрэглээний эрх

1.5.1 Багцад дагалдах эрх нь хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын хураамжид дагалдах хэрэглээний эрх юм.

1.5.2 Сүлжээндээ хязгааргүй ярианы эрх сонгосон бол Мобикомын сүлжээнд дуудлага хийх хэрэглээний хязгаарлалтгүй байна.

1.5.3 Сүлжээ харгалзахгүй хязгааргүй ярианы эрх сонгосон бол Монголын үүрэн болон суурин операторын бүх сүлжээнд дуудлага хийх хэрэглээний хязгаарлалтгүй /зүй /байна.

1.5.4 Ярианы эрхээс гадуурх хэрэглээнд:

1.5.4.1 Видео дуудлага

1.5.4.2 Урамшуллын ярианы минут

1.5.4.3 Роуминг яриа

1.5.4.4 Улс хоорондын яриа

1.5.4.5 Түсгай дугаар руу холбогдсон ярианы хэрэглээ болон бусад энд тусгагдаагүй хэрэглээнүүд байна.

1.5.5 Дата хэрэглээний эрхэд:

1.5.5.1 Үйлчилгээ үзүүлэгчийн 2G, 3.5G, 4G сүлжээнд ашигласан дата хэрэглээ байна.

1.5.6 Дата хэрэглээний эрхээс гадуурх хэрэглээнд:

1.5.6.1 Дата роуминг

1.5.6.2 Хэрэглэгчийн хүсэлтээр авсан нэмэлт дата багцын хэрэглээнүүд байна.

1.5.7 Мессэж дээр суурилсан нэмэлт үйлчилгээ, контент, дата багц,нэгж шилжүүлэх зэрэг нэмэлт хэрэглээнүүд нь багцад дагалдах хэрэглээний эрхэд хамаарахгүй.

1.5.8 Багцад дагалдах хэрэглээний эрх ашиглах:

1.5.8.1 Багцад дагалдах хэрэглээний эрхээс гадуурх яриа болон мессэж хэрэглээ нь Хавсралт 2-т заасан үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний үндсэн тарифын дагуу тооцогдоно.

1.5.8.2 Хэрэглэгчийн тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата хэрэглээний эрхийн үлдэгдэл нь дараа сардаа шилжихгүй.

1.5.8.3 Багцад дагалдах дата эрх болон нэмэлт дата багцууд нь идэвхжүүлсэн хугацаанаас үл хамааран дараах дараалын дагуу ашиглагдана. Үүнд:

- Нэмэлт дата багц
- Дагалдах дата багц

1.5.8.4 Дата хэрэглээний эрх болон дата багц сонгоогүй хэрэглэгч дата хэрэглээг 128kbps хурдаар хэрэглээний хязгааргүй ашиглах боломжтой.

1.6 Барьцаа төлбөр

1.6.1 Шинэ хэрэглэгч үйлчилгээ авахдаа сонгосон багцаас хамааран Хавсралт 2.1-д заасны дагуу үндсэн барьцааг байршуулна.

1.6.2 Барьцаа төлбөр нь төлбөрийн үлдэгдэлд суутгагдсан хэрэглэгч үйлчилгээг дахин ашиглахын тулд тухайн багцад харгалзах барьцаа төлбөрийг дахин байршуулна.

1.6.3 Роуминг үйлчилгээний эрх нээлгэх хэрэглэгч нь хэрэв улс хоорондын ярианы эрхийн барьцаа байршуулсан бол роуминг үйлчилгээний барьцааны зөрүү, улс хоорондын ярианы эрхийн барьцаа байршуулаагүй бол роуминг үйлчилгээний барьцааг бүтэн байршуулна.

1.6.4 Хэрэглэгч ярианы роуминг үйлчилгээний эрхээ хаалгасан сарын билл бодогдсоны дараа үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулснаар роуминг үйлчилгээний барьцаагаа буцаан авах боломжтой.

1.7 Найдвартай хувь хэрэглэгчийн барьцаа төлбөрийг буцаах

1.7.1 Дараа төлбөрт дугаараа 6-аас дээш жил ашиглаж байгаа найдвартай хувь хэрэглэгчийн барьцаа төлбөрийг төлбөрт суутгах замаар барьцаа төлбөрөөс чөлөөлнө.

1.7.2 Найдвартай хувь хэрэглэгчид барьцаа төлбөрийг буцаах нь үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн батлагдсан хөтөлбөрийн хүрээнд зохицуулагдана.

1.7.3 Барьцаа төлбөрийг буцаах шалгуур хангасан хэрэглэгчид рүү үйлчилгээ үзүүлэгч утсаар болон мессэжээр мэдээлэл хүргэнэ.

1.8 Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл

1.8.1 Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл /цаашид "ХХНН" гэх/ гэж хэрэглэгч өөрийн хэрэглээгээ хянах боломжийг олгох зорилгоор хэрэглээг үе шаттайгаар мэдээлэх, хэрэглээ хязгаарлах төвшнөөс хэтэрсэн тохиолдолд гарах хэрэглээг хязгаарлах нөхцөлийг хэлнэ.

1.8.2 Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл нь зөвхөн тухайн сарын багцын хураамж дээр бусад хэрэглээний дүнг оруулж тооцсон дүнгээр гарах хэрэглээг хязгаарлана.

1.8.3 Миний моби багцын хэрэглээ хязгаарлах төвшин нь Хавсралт 1-т заасан дүнгээртооцогдоно.

1.8.4 Хэрэглэгч богино хугацаанд их хэмжээний хэрэглээ хийснээс хамаарч хэрэглээний дүн хоцрогдолтой мэдээлэгдэж болно.

1.8.5 Сар бүрийн 1-нээс 4-ний өдрүүдэд төлбөрийн нэхэмжлэх боловсруулагддаг тул хэрэглээг мэдээлэх боломжгүй.

1.8.6 Хэрэглээний дүн 1.8.4, 1.8.5-д заасан шалтгааны улмаас хэрэглээ хязгаарлах төвшинд хүрсэн болон хэтэрсэн тохиолдолд анхааруулах мессэж очихгүйгээр гарах хэрэглээг хязгаарлаж болно.

1.8.7 Гарах хэрэглээ хязгаарлагдсан хэрэглэгчийн төлсөн мөнгөн дүнгээр гарах хэрэглээний эрх нээгдэнэ.

1.8.8 Хэрэглэгч үүрэн холбооны дугаар дээрээ гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авах, ярианы роуминг үйлчилгээг идэвхжүүлэх, гэрээн дээрээ нэмэлтээр өрхийн интернэт, MNP75, VOO үйлчилгээг авах бол хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөлийг цуцална.

Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөлийг идэвхжүүлэх

1.8.9 Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөлийг хугацаатай болон хугацаагүй идэвхжүүлнэ.

1.8.10 Дараах хэрэглэгчид ХХНН-г заавал идэвхжүүлнэ.

1.8.10.1 Шинэ хэрэглэгчид эхний 6 сарын хугацаатай

1.8.10.2Гадаадын иргэн бол хугацаагүй

1.8.10.3Задгай хаягтай бол хугацаагүй

1.8.10.4 Цахим үнэмлэхний хаягаас өөр нутаг дэвсгэрт гэрээ байгуулсан бол хугацаагүй

1.8.10.5 Цахим үнэмлэхийн хугацаа дуусан хэрэглэгчид хугацаагүй

1.8.10.6 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний салбаргүй сумын иргэн бол хугацаагүй.

1.8.11 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр хугацаатай, хугацаагүй хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл идэвхжүүлж болно.

Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөлийг цуцлах

1.8.12 Шинэ хэрэглэгчийн хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл 7 дахь сарын эхний өдөр автоматаар цуцлагдана.

1.8.13 Дараах хэрэглэгчид доорх нөхцөлийг хангасан тохиолдолд үйлчилгээний төвд ханда ХХНН-ийг цуцлуулах боломжтой. Үүнд:

1.8.13.1 Задгай хаягтай болон цахим үнэмлэхний хаягаас өөр нутаг дэвсгэрт гэрээ байгуулсан хэрэглэгч шинэчлэгдсэн хаягтай цахим үнэмлэхээ авчирсан тохиолдолд

1.8.13.2 Үйлчилгээ үзүүлэгчийн салбаргүй сумын хэрэглэгч тухайн суманд салбар нээгдвэл

1.8.13.3 Гадаадын иргэнд 1.8.13-т заасан нөхцөл хамаарахгүй.

mobicom

ДАРААТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МИНИЙ МОБИ БАГЦЫН НӨХЦӨЛ

/ Хувь хэрэглэгч /

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО

2.1 Хэрэглээний алхам

2.1.1 Ярианы тариф нь хот хоорондоо болон хот доторх ярианд эхний бүрэн ба бүрэн бус 1 минутыг 1 минутаар, 61 дэх секундээс 1 секундийн алхмаар тооцогдоно.

2.1.2 Ярианы тариф нь улс хоорондын ярианы эхний бүрэн ба бүрэн бус 6 секунд хүртэлх яриа 6 секундээр, 7 дахь секундээс 1 секундийн алхмаар тооцогдоно.

2.1.3 Роуминг ярианы тариф 1 минутын алхмаар тооцогдоно.

2.1.4 Тусгай дугаар руу ярих ярианы алхам нь тухайн тусгай дугаарын операторын нөхцөлөөр зохицуулагдана.

2.2 Төлбөрийн нэхэмжлэх

2.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг сар бүрийн 1-нээс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 5-ны дотор хэрэглэгчээс нэхэмжилнэ.

2.2.2 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын хураамж, сарын хэрэглээний дүнгээс зохих хөнгөлөлтийг хасч тооцсоны дараах дүн, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл, гар утас төхөөрөмжийн зээлтэй бол гар утас төхөөрөмжийн зээлийн төлбөр, НӨАТ зэргээс бүрдэнэ.

2.2.3 Хэрэглэгч төлбөрийг нэхэмжилсэн сарын 12-ны дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

2.2.4 Төлбөрөө 9 сар төлсний дараа төлбөр төлөх хугацаа нэхэмжилсэн сарын 20-ны дотор болж өөрчлөгдөнө.

2.2.5 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг Мобиком апликейшн, www.mobicom.mn вэб, мобайл банк 2.0, үйлчилгээ үзүүлэгчийн заасан дансанд болон бусад боломжит сувгаар төлнө.

2.2.6 Төлбөрөөс хаалттай дугаарын төлбөр бүрэн төлөгдөх хүртэл үйлчилгээ үзүүлэх боломжгүй.

ГУРАВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Нэмэлт дата багц

3.1.1 Нэмэлт дата багцын үнэ тариф нь үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн нөхцөлөөр зохицуулагдана.

3.1.2 Нэмэлт дата багцын хүчинтэй хугацаа нь багц авсан өдрөөс эхлэн тооцогдож, тухайн идэвхжүүлсэн дата багцын хэмжээгээр хэрэглээ хязгаарлагдана.

3.1.3 Нэмэлт дата багцыг сарын хэдний өдөр идэвхжүүлснээс үл хамааран дата багцын төлбөрийг бүтэн нэхэмжилнэ.

3.1.4 Нэмэлт дата багц нь сарын хэдний өдөр идэвхжүүлснээс үл хамааран сонгосон багцын хүчинтэй хугацаанд ашиглах бөгөөд багцын хугацаа дуусахад хэрэглэгдээгүй үлдсэн дата мөн адил дуусгавар болно. Харин хугацаа дуусахаас өмнө дата багцын хэмжээ дуусан тохиолдолд багцын хүчинтэй хугацаанд 128Kbps хурдаар үйлчилгээгээ ашиглана.

3.1.5 Нэмэлт дата багцын эрх нь зөвхөн үйлчилгээ үзүүлэгчийн 2G, 3.5G, 4G сүлжээнд ашигласан хэрэглээнд хамаарна.

3.1.6 Сар бүр автоматаар сунгагдах нэмэлт дата багц идэвхжүүлсэн тохиолдолд сарын хураамжийг тухайн сарын ашигласан хоногт дүйцүүлэн нэхэмжилнэ.

3.2 Нэмэлт мессэж багц

3.2.1 Сүлжээндээ хязгааргүй мессэж бичих нэмэлт багц идэвхжүүлсэн бол Мобикомын сүлжээнд мессэж илгээхэд хэрэглээний хязгаарлалтгүй / зүй зохистой хэрэглээнд / байна.

3.2.2 Сүлжээ харгалзахгүй мессэж бичих нэмэлт багц идэвхжүүлсэн бол Монголын үүрэн операторын бүх сүлжээ рүү мессэж илгээхэд хэрэглээний хязгаарлалтгүй / зүй зохистой хэрэглээнд / байна.

3.2.3 Нэмэлт мессэж багцаас гадуурх хэрэглээнд:

3.2.3.1 Улс хоорондын мессэж

3.2.3.2 Роуминг мессэж

3.2.3.3 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээ идэвхжүүлэх тусгай дугаар руу бичсэн мессэж

3.2.3.4 Төлбөрт лавлах болон тусгай дугаар руу бичсэн мессэж хэрэглээ болон бусад эндтусгагдаагүй хэрэглээнүүд байна.

3.2.4 Сар бүр автоматаар сунгагдах нэмэлт мессэжний багц идэвхжүүлсэн тохиолдолд сарын хураамжийг тухайн сарын ашигласан хоногт дүйцүүлэн нэхэмжилнэ.

3.2.5 Сар бүр автоматаар сунгагдах үйлчилгээ гэж хэрэглэгчийн идэвхжүүлсэн үйлчилгээг тус хэрэглэгч өөрөө цуцлах хүртэл автоматаар сар бүр сунгагдаж харгалзах сарын хураамж нэхэмжлэгдэхийг хэлнэ.

3.3 WE нэмэлт үйлчилгээ

3.3.1 WE үйлчилгээ нь 1 admin дугаар болон 5 хүртэлх гишүүн дугааруудаас бүрдсэн байна. Admin дугаар нь гишүүдээ нэмж групп үүсгэн хоорондоо хязгааргүй ярина/ зүй зохистой хэрэглээнд /.

3.3.2 WE үйлчилгээг идэвхжүүлснээс хойш хэрэглэгч өөрийн хүсэлтээр цуцлах хүртэл сар бүр автоматаар сунгагдана.

3.3.3 Admin дугаар нь дараах эрхтэй байна.

3.3.3.1 Группд гишүүн нэмэх

3.3.3.2 Группээс гишүүн хасах

3.3.3.3 Группд бүртгэлтэй гишүүдээ харах

3.3.3.4 Группийн admin ыг солих

3.3.3.5 Групп устгах

3.3.3.6 Сар бүр 5GB дата авто цэнэглэгдэх үйлчилгээг идэвхжүүлэх

3.3.3.7 Сар бүр 5GB дата авто цэнэглэгдэх үйлчилгээг цуцлах

3.3.3.8 Нэмэлтээр 5GB дата багц идэвхжүүлэх

3.3.4 Сар бүр 5GB дата авто цэнэглэгдэх үйлчилгээ:

3.3.4.1 Admin хэрэглэгч сар бүр 5GB дата авто цэнэглэгдэх үйлчилгээг идэвхжүүлэх боломжтой байна.

3.3.4.2 Admin хэрэглэгч 5GB дата авто цэнэглэгдэх үйлчилгээг идэвхжүүлсэн өдөр болон дараа сараас эхлэн сар бүрийн 1-нд автоматаар идэвхэжнэ.

3.3.4.3 Сар бүр 5GB авто цэнэглэгдэх үйлчилгээг идэвхжүүлсэн WE групп тухайн сардаа 5GB датаг нэмэлтээр дахин нэг удаа цэнэглэх боломжтой.

3.3.4.4 WE үйлчилгээний 5GB датаг бүх гишүүд ашиглах боломжтой байна.

3.3.4.5 WE үйлчилгээний нөхцөлөөр идэвхжүүлсэн дата багцын төлбөр нь admin дугаарын төлбөр дээр нэмэгдэж нэхэмжлэгдэнэ.

3.3.5 WE үйлчилгээнд бүртгэлтэй гишүүдийн дугаарт автоматаар нэгж цэнэглэх үйлчилгээ.

3.3.5.1 Өөрийн дугаараас бусад урьдчилсан төлбөрт болон хосолсон төлбөрт багцтай WE үйлчилгээний гишүүдийг сар бүр автоматаар нэгж цэнэглэх боломжтой байна.

3.3.5.2 Хэрэглэгч үйлчилгээг идэвхжүүлсэн өдөр болон дараа сарын 1-ний өдрөөс эхлэн сар бүрийн 1-нд автоматаар нэгж цэнэглэлт хийгдэнэ.

3.3.5.3 Нэгж цэнэглэх үйлчилгээг ашиглан тооцогдсон төлбөр нь хэрэглэгчийн сонгосон үйлчилгээний багцын сарын суурь хураамж дээр нэмэгдэж нэхэмжлэгдэнэ.

3.3.5.4 Хэрэглэгч хүсэлт илгээж үйлчилгээг цуцлах хүртэл сар бүрийн 1-нд нэгж цэнэглэлт автоматаар хийгдэж төлбөр тооцогдоно.

ДӨРӨВ. РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1 Дараа төлбөрт хэрэглэгч роуминг үйлчилгээг ашиглан дараах үйлчилгээнүүдийг авна.

4.1.1 Өөрийн дугаар бүхий гар утсаа ашиглан гадаадад дуудлага хийх хүлээн авах

4.1.2 Мессэж илгээх хүлээн авах

4.1.3 Дата багц болон дата роуминг үйлчилгээг задгайгаар ашиглан дата, контент, программ хангамж, апликейшн татах, ашиглах, интернэтэд хандах, и-мэйл хүлээн авч, хариу өгөх гэх мэт.

4.1.4 Зарим нэмэлт үйлчилгээнүүдийг ашиглах

4.2 Хэрэглэгчийн сонгосон операторoос хамааран яаралтай тусламжийн төв, хэрэглэгчийн үйлчилгээний дугаарт холбогдох үед төлбөр нэхэмжлэгдэнэ.

4.3 Ярианы роуминг үйлчилгээ

4.3.1 Дараа төлбөрт хэрэглэгч ярианы роуминг үйлчилгээний эрх нээлгэхдээ үйлчилгээний салбарт хандан Хавсралт 2.1-д заасан барьцаа төлбөрийг байршуулна.

4.3.2 Гэрээний шаардлага хангаагүй болон дараах хэрэглэгчдэд ярианы роуминг үйлчилгээг үзүүлэх боломжгүй. Үүнд:

4.3.2.1 Задгай хаягтай бол

4.3.2.2 Гадаадын иргэн бол

4.3.2.3 Цахим үнэмлэхний хаягаас өөр нутаг дэвсгэрт гэрээ байгуулсан.

4.4 Мессэж роуминг үйлчилгээ

4.4.1 Хэрэглэгч гадаад оронд зорчихдоо өөрийн дугаар, гар утсаа ашиглан үйлчилгээ үзүүлэгчийн гэрээ хийсэн операторуудын сүлжээнд мессэж илгээх, хүлээн авах, дуудлага хүлээн авах болон бусад нэмэлт үйлчилгээг ашиглах боломжийг олгох үйлчилгээ юм.

4.4.2 Мессэж роуминг үйлчилгээг идэвхжүүлэхдээ үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээнд байхдаа 599 тусгай дугаарт “on” гэсэн мессэжийг илгээнэ.

4.4.3 Ярианы роуминг үйлчилгээний барьцаа байршуулж эрх нээлгээгүй хэрэглэгч мессэж роуминг үйлчилгээг идэвхжүүлэхэд дуудлага хүлээн авах үйлчилгээ давхар идэвхжих бөгөөд хэрэглэгч 599 дугаарт “off voice” гэсэн мессэж илгээн дуудлага хүлээн авах үйлчилгээг цуцлах боломжтой.

4.4.4 Мессэж илгээх болон дуудлага хүлээн авах үйлчилгээний төлбөр нь тухайн зорчиж буй оронд мөрдөгдөх тогтоосон тарифын дагуу нэхэмжлэгдэнэ.

4.4.5 Мессэж роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгч гарах дуудлага хийх боломжгүй боловч тухайн улсын түргэн тусламжийн

утас болон операторын лавлах руу ярих эрх нээлттэй байх бөгөөд операторын үнэ тарифаас шалтгаалан төлбөр тооцогдоно.

4.4.6 Мессэж роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгчийн тухайн сарын нийт хэрэглээ 300'000 төгрөгөөс хэтэрсэн тохиолдолд үйлчилгээний эрхийг хязгаарлана. Роумингийн хэрэглээ хоцрогдолтой бодогдох болон хэрэглэгчийн ашигласан хэрэглээнээс хамаарч энэхүү хэмжээнээс хэтэрч хаагдах боломжтой.

4.4.7 Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөлтэй хэрэглэгч мессэж роуминг үйлчилгээ ашиглахад хэрэглээ хязгаарлах төвшнөөр хэрэглээ нь хязгаарлагдана.

4.4.8 Хэрэглэгчийн мессэж роуминг үйлчилгээний эрх нь хаагдсан тохиолдолд үйлчилгээний салбарт хандан бүх төлбөр тооцоог барагдуулснаар үйлчилгээний эрхийг дахин нээлгэх боломжтой.

4.5 Дата роуминг үйлчилгээ

4.5.1 Дата роуминг үйлчилгээг ярианы эсвэл мессэж роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгч ашиглана.

4.5.2 Ярианы роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгчийн дугаарт дата роуминг үйлчилгээний эрх нээлттэй байна. Харин мессэж роуминг үйлчилгээтэй хэрэглэгч дата роуминг үйлчилгээг идэвхжүүлэхдээ 599 тусгай дугаарт “on data” мессэжийг илгээнэ.

4.5.3 Хэрэглэгчийн ашиглаж буй төхөөрөмж эсвэл гар утаснаас тухайн роуминг гэрээтэй операторын сүлжээнд холбогдохоор дохио дамжуулах мөчөөс эхлэн дата үйлчилгээний төлбөр тооцогдоно.

4.6 Дата роуминг багц

4.6.1 Мессэж роуминг болон дата роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн, роуминг апплет суулгасан симтэй хэрэглэгч дата роуминг багцуудыг ашиглана.

4.6.2 Дата роуминг багцын хугацаа нь багц авсан өдрөөс эхлэн тооцогдож, тухайн багцад харгалзах дата эрхийн хэмжээгээр хязгаарлагдана. Дата роуминг үйлчилгээгээ хаах бол “ off data” гэсэн мессэжийг 599 дугаарт илгээнэ.

4.6.3 Дата роуминг багцын хүчинтэй хугацаа эсвэл хэмжээ дууссан үед дугаарын интернэтэд хандах эрх хаагдах бөгөөд хэрэглэгч цаашид дата роуминг үйлчилгээг задгайгаар ашиглахыг хүсвэл “on z” гэсэн мессэжийг 599 дугаарт илгээж нээж болно.

4.6.4 Дата роуминг үйлчилгээг задгайгаар ашиглах эрхээ нээсэн үед “off z”гэсэн мессэжийг 599 дугаарт илгээж хаагаагүй тохиолдолд хэрэглэсэн интернэт хэрэглээг задгай хэрэглээний тарифаар тооцож нэхэмжилнэ.

4.6.5 Хэрэглэгч ижил төрлийн роуминг дата багцуудыг давхар идэвхжүүлэх боломжгүй байна. Харин өөр төрлийн роуминг дата багцуудыг давхар идэвхжүүлсэн тохиолдолд хэрэглэгч аль улсад байгаагаас хамаарч харгалзах улсын дата багцаас хэрэглээг тооцно.

4.6.6 Хэрэглэгч “B” үсгийг 599 тусгай дугаарт илгээж дата роуминг багцын хэрэглээ болон хугацааг шалгах боломжтой.

4.7 Роуминг үйлчилгээг ашиглахад анхаарах зүйлс:

4.7.1 Роуминг үйлчилгээний үнэ тарифын мэдээллийг www.mobicom.mn вэбээс харах болон тухайн улсынхаа нэрийг Англи хэл дээр бичээд 599 дугаарт мессэжээр илгээн мэдэх боломжтой.

4.7.2 Хэрэглэгч ашиглаж буй улсынхаа сонгосон операторын үнэ тарифтай танилцаагүй нь роумингийн төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4.7.3 Роуминг үйлчилгээг ашиглаж буй хэрэглэгч бусад улсын сүлжээнээс Үйлчилгээний нэгдсэн төв 976-1800-2222 лавлах руу үнэ төлбөргүй холбогдоно.

4.7.4 Дата роуминг үйлчилгээг ашиглахад тухайн улсын тарифаас шалтгаалан төлбөр өндөр гарах тул хэрэглэгч хэрэглээгээ тогтмол шалгах хэрэгтэй. Ухаалаг үйлдлийн системтэй гар утаснууд автоматаар програм хангамжаа шинэчилдэг учир дата роуминг ашиглах шаардлагагүй тохиолдолд интернэт тохиргоогоо утсан дээрээ хаах боломжтой.

ТАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 Багц солих

5.1.1 Багц солих гэдэг нь дугаараа солихгүйгээр багцын төрлөө өөрчлөхийг хэлэх ба гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч багцаа бууруулах боломжгүй.

5.1.2 Хэрэглэгч багц бууруулан бага барьцаа төлбөрийн нөхцөлтэй багц руу шилжиж байгаа тохиолдолд барьцаа төлбөрийн зөрүүг хэрэглэгчийн хүсэлтээр төлбөрөөс хөнгөлөх замаар олгоно.

5.1.3 Хосолсон төлбөрт болон дараа төлбөрт багцаас Миний Моби багц руу шилжих үйлчилгээг хүсэлт гаргасан тухайн өдөрт нь биелүүлэх бөгөөд багцад дагалдах хэрэглээний эрхүүдийн сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн нэхэмжилж багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

5.1.4 Миний моби багцаас бусад дараа төлбөрт болон хосолсон төлбөрт багц руу шилжих үйлчилгээг хүсэлт гаргасан өдөрт нь идэвхжүүлнэ. Багцын сарын хураамжийг тухайн сарын үлдсэн хоногт дүйцүүлэн бодож, дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

5.2 Урьдчилсан төлбөрт хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнд шилжих:

5.2.1 Миний моби багцад шилжих хүсэлтийг тухайн өдөрт нь биелүүлэх ба багцад дагалдах хэрэглээний эрхүүдийн хувьд сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн нэхэмжилж багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

5.2.2 Урьдчилсан төлбөрт хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнд шилжихэд хэрэглэгчийн ашигласан хугацаа, хэрэглээний түүх хэвээр үлдэнэ.

5.2.3 Урьдчилсан төлбөрт хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнд шилжихэд хэрэглэгчийн дансан дахь нэгж устах бөгөөд дараа сард хэрэглэгчийн шилжин орсон дараа төлбөрт үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийн эцсийн дүнгээс устсан нэгжийн дүнгээр (1 нэгжийг 1 төгрөгөөр тооцно) хасч тооцно.

5.2.4 Хэрэглэгчийн багц хооронд шилжих үеийн дансан дахь хоногийн үлдэгдлийг тухайн өдрөөс эхлэн 180 хоног хадгалах ба 181 дэх хоногоос үлдэгдэл хоногийгустгана.

5.2.5 Хэрэглэгчийн нэмэлт үйлчилгээний эрхийг хэвээр шилжүүлэх бөгөөд нэмэлт үйлчилгээний эрх дууссан тохиолдолд хэрэглэгч үйлчилгээний эрхээ цуцлах хүсэлт гаргаагүй бол шилжин орсон дараа төлбөрт үйлчилгээн дээр нэмэлт үйлчилгээг үргэлжлүүлэн идэвхжүүлнэ.

5.2.6 Нэмэлт үйлчилгээний контентын архив дугаараа дагаж хэвээр шилжинэ.

5.3 Дараа төлбөрт хэрэглэгч урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих:

5.3.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээний дугаартай хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнээс урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой.

5.3.2 Тухайн сарын төлбөрийн нэхэмжлэх бодогдсоноос хойш урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой.

5.3.3 Дараа төлбөрт багцын дагалдах хэрэглээний эрхээс ашиглаагүй үлдсэн эрх нь устана.

5.3.4 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжсэн тухайн сарын багцад дагалдах хэрэглээний эрхийн сарын хураамжийг ашигласан хоногт нь дүйцүүлэн нэхэмжлэх бөгөөд нэмэлт хэрэглээг бүтэнолгоно.

5.3.5 Хэрэглэгчийн төлбөрийг багц шилжих тухайн үед бодогдсон дүнгээр тооцож авна. Тухайн сарын төлбөр дараа сард бодогдоход хэрэглэгчийн урьдчилан төлсөн төлбөрт зөрүү гарсан тохиолдолд доорх байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

5.3.5.1 Хэрэглэгч илүү төлөлт хийсэн тохиолдолд илүү төлөлтийг дараа сарын 15-нд багтаан нэгж хэлбэрээр хэрэглэгчийн дансанд буцаан олгоно.

5.3.5.2 Үлдэгдэл төлбөр үүссэн тохиолдолд хэрэглэгч дараа сарын 15-нд багтаан үлдэгдэл төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дансан дахь нэгжээс суутгана.

5.3.6 Дараа төлбөрт үйлчилгээнд шилжсэнээс хойш 180 хоногийн дотор урьдчилсан төлбөрт үйлчилгээнд буцаж шилжиж байгаа тохиолдолд үлдэгдэл хоногийг хэвээр үүсгэнэ.

5.3.7 Дараа төлбөрт үйлчилгээнд шилжсэнээс хойш 180 хоног хэтэрсэн тохиолдолд хэрэглэгчийн дугаарыг 90 хоногтой сэргээх ба хэрэглэгч идэвхтэй хэрэглээ хийж дугаарын эрхээ сунгана.

5.3.8 Дугаарын ашигласан хугацаа нь үргэлжилж тооцогдоно.

5.3.9 Нэмэлт үйлчилгээний контентын архив дугаарт хэвээр үлдэнэ.

5.3.10 Хугацаатай үйлчилгээний багц ашиглаж буй хэрэглэгч үйлчилгээний хугацаа дуусахаас өмнө урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих тохиолдолд хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ цуцалж буйд тооцон төлбөрийг барагдуулна.

5.4 Миний мобибагц дотроо шилжих

5.4.1 Хэрэглэгч Миний моби багцын яриа, мессэж болон дата хэрэглээний эрхүүдээ зэрэг эсвэл дангаар нь өөрчлөх хүсэлтийг тухайн өдөрт нь сард 1 удаа өөрчилнө.

5.4.2 Багцад дагалдах хэрэглээний эрхүүдийн сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн нэхэмжилж багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

5.5 Гэрээ шилжүүлэх

5.5.1 Гэрээ шилжүүлэх гэдэг нь дугаар эзэмших эрхээ өөр хэрэглэгчид шилжүүлэхийг хэлнэ.

5.5.2 Гэрээ шилжүүлэх үйлчилгээг хэрэглэгчийн төлбөрийн нэхэмжлэх бодогдсоноос хойш тухайн сарын сүүлийн өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэх боломжтой.

5.5.3 Шинэ хэрэглэгч үйлчилгээг хамгийн багадаа 1 сар ашигласны дараа гэрээ шилжүүлэх боломжтой.

5.5.4 Гэрээ шилжүүлэхэд тухайн хэрэглэгч төлбөр тооцооны үлдэгдэлгүй байх шаардлагатай.

ДАРААТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МИНИЙ МОБИ БАГЦЫН НӨХЦӨЛ

/ Хувь хэрэглэгч /

5.5.5 Багцад дагалдах хэрэглээний эрх нь тухайн дугаарт сард 1 удаа олгогдох тул гэрээний шинэ хэрэглэгчид багцад дагалдах хэрэглээний эрх шинээр олгогдохгүй ба зөвхөн гэрээний хугацаанд хэрэглэгчийн ашиглаагүй үлдсэн багцад дагалдах хэрэглээний эрх олгогдоно.

5.5.6 Гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч гэрээ шилжүүлэх боломжгүй бөгөөд гэрээгээ шилжүүлэх зайлшгүй шаардлагатай бол 7.1-д заасан хэрэглэгчийн хүсэлтээр гэрээ цуцалж буйд тооцон төлбөр тооцоог барагдуулсны дараа гэрээг шилжүүлэх боломжтой.

5.6 Дугаар солих

5.6.1 Дугаар солих гэдэг нь гэрээний эзэмшигч болон багцын төрлөө өөрчлөхгүйгээр дугаараа өөрчлөхийг хэлэх ба гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч дугаараа солих боломжгүй.

5.6.2 Хэрэглэгч дугаар солих үйлчилгээг авах бол хүсэлт гаргасан тухайн өдөрт нь үйлчилгээг идэвхжүүлж өгнө.

5.6.3 Дугаар солих үйлчилгээг сард нэг удаа авах боломжтой.

5.6.4 Урьдчилсан төлбөрт дугаараа дараа төлбөрт үйлчилгээний дугаараар солих боломжгүй.

5.7 Дугаар түр хаах

5.7.1 Дугаар түр хаах гэдэг нь хэрэглэгчийн хүсэлтээр дугаарын орох гарах яриа, мессэж эрх болон дата эрхийг түр хаахыг хэлнэ.

5.7.2 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар түр хаасан тохиолдолд тухайн сарын хураамж болон төхөөрөмжийн төлбөр нэхэмжлэгдэнэ.

5.7.3 Дугаараа түр хаалгасан хэрэглэгч нэхэмжилсэн төлбөрийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд дугаар төлбөрөөс хаалттай төлөвт шилжинэ.

5.8 Дугаар хадгалах

5.8.1 Дугаар хадгалах үйлчилгээ гэж хэрэглэгчийн хүсэлтээр дугаарын үйлчилгээний эрхийг төлбөртэй нөхцөлөөр 12 сар хүртэлх хугацаанд хадгалахыг хэлнэ.

5.8.2 Шинэ хэрэглэгч нь хамгийн багадаа 3 сар дугаараа ашиглаж байж дугаараа хадгалуулах эрхтэй болно.

5.8.3 Гар утас зээлээр эсхүлл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан мөн хугацаатай багцын гэрээ байгуулсан хэрэглэгч тухайн гэрээний хугацаанд дугаараа хадгалах боломжгүй.

5.8.4 Дугаар хадгалах хугацааг хуанлийн бүтэн сараар тооцох бөгөөд нэг удаад 12 сараас ихгүй хугацаагаар хадгалах боломжтой байна.

5.8.5 12 сар хадгалсан дугаарыг 1 сар ашигласны дараа дахин хадгалуулах эрхүүснэ.

5.8.6 Хэрэглэгч дугаараа хадгалуулах тохиолдолд Хавсралт 2.8-д заасан төлбөртэй нөхцөлөөр хадгалуулах боломжтой.

5.8.7 Дугаараа хадгалуулах хэрэглэгчийн дугаар нь төлбөрийн үлдэгдэлгүй байх шаардлагатай ба дугаар хадгалуулах төлбөрөө урьдчилж төлнө.

5.8.8 Дугаар хадгалуулах үйлчилгээг идэвхжүүлэх нь хэрэглэгчийг төлбөр төлөх үүргээс чөлөөлөхгүй.

5.8.9 Хэрэглэгчийн дугаар хадгалах үйлчилгээг сар бүрийн 1-ний өдөр идэвхжүүлж, үйлчилгээний эрхийг бүрэн хаана. Хэрэв сарын 1-нээс хойш хэрэглэгч дугаараа хадгалуулах хүсэлт гаргасан бол дугаарыг түр хааж, дараа сарын 1-нээс дугаар хадгалах төлөвт шилжинэ.

5.8.10 Хэрэв хэрэглэгч сарын 1-нээс хойш дугаараа хадгалуулах хүсэлт гаргасан бол тухайн сард хэрэглээ хийсэн эсэхээс үл хамааран сарын хураамжийг бүтэн нэхэмжилж, харгалзах дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгож төлбөр бодогдоно. Хадгалуулах үйлчилгээ авсан тухайн сарыг хадгалах хугацаанд оруулж тооцохгүй

5.8.11 Хэрэглэгч сар бүрийн 1-нээс 4-ний хооронд (өмнөх сарын төлбөр бодогдоогүй үед) дугаар хадгалуулах хүсэлт гаргасан тохиолдолд гэрээний нөхцөлийн дагуу тухайн сарын 12-ны дотор өмнөх сарын төлбөрөө, харин тухайн хүсэлт гаргасан сарын төлбөрөө дараа сарын 12-ны дотор бүрэн төлөх үүрэгтэй.

5.8.12 Хэрэглэгч дараах сувгуудаар хандаж дугаараа хадгалуулах боломжтой. Үүнд:

5.8.13.1. Үйлчилгээний салбар

5.8.13.2. Мобиком аппликейшн

5.8.13 Дугаар хадгалуулсан хугацаа нь хэрэглэгчийн дугаарын ашигласан хугацаанд тооцогдоно.

5.8.14 Хэрэглэгчийн хүсэлт гаргасан дугаар хадгалах хугацаа дуусахад дараа сарын 1-нд дугаарын эрх автоматаар нээгдэж тухайн сарын хураамжийг бүтэн нэхэмжлэх ба харгалзах дагалдах хэрэглээний эрхийг олгоно.

5.8.15 Дугаар хадгалах хугацаа дуусч дугаарын эрх автоматаар нээгдэх үед төлбөрийн үлдэгдэлтэй болон төлбөр төлөх хугацаа хэтэрсэн бол төлбөрөөс хаалттай төлөвт шилжих эсвэл 7.2.2-ын дагуу төлбөрөөс цуцлагдана.

5.8.16 Дугаар хадгалуулах хүсэлт гаргахдаа хэрэглэгч багцад дагалдах эрхээ бүрэн ашиглаагүй бол үлдэгдэл эрх нь дугаар нээх сард нөхөн олгогдохгүй.

5.9 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар нээх

5.9.1 Хэрэглэгчийн хүсэлт гаргасан өдөр дугаарыг нээх боломжтой.

5.9.2 Сарын дундуур дугаар нээлгэж байгаа тохиолдолд сарын хураамжийг сарын үлдсэн өдөрт дүйцүүлэн нэхэмжилж харгалзах багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

5.9.3 Хэрэглэгч дугаараа нээлгэх үед төлбөрийн үлдэгдэлтэй бол төлбөрөө бүрэн барагдуулахүүрэгтэй.

5.9.4 Төлбөрөөс хаалттай дугаарыг нээлгэж байгаа тохиолдолд сарын хураамжийг бүтэн нэхэмжилж харгалзах багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэнолгоно.

5.9.5 Хэрэглэгч дугаар хадгалуулсан хугацаагаа дуусахаас өмнө нээлгэх бол хүсэлтээ дараах сувгуудаар өгөх боломжтой. Үүнд:

5.9.5.1 Үйлчилгээний салбарт

5.9.5.2 2222 лавлах шугамд (бусад сүлжээнээс 1800-2222)

5.9.6 Дугаараа төлбөртэй хадгалуулсан хэрэглэгч хугацаанаас өмнө дугаараа нээлгэх бол үлдсэн сар /хуанлийн бүтэн сар/-ын дугаар хадгалах үйлчилгээний төлбөрийг хэрэглэгчийн хүсэлтээр дараах хоёр төрлөөр буцаан олгох боломжтой. Үүнд:

5.9.6.1 Хэрэглэгчийн төлбөрөөс хасах

5.9.6.2 Хэрэглэгчид бэлнээр олгох

5.10 Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт гаргах

5.10.1 Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт нь хэрэглэгчийн дугаарын сүүлийн 3 сарын гарах хэрэглээний ашигласан хэмжээ, огноо, бодогдсон төлбөр зэргийг агуулсан мэдээлэл байна.

5.10.2 Тухайн сарын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг сарын 5-аас эхлэн авах боломжтой.

5.10.3 Хэрэглэгч дугаараа байгууллагын гэрээнээс хувь хэрэглэгчийн гэрээнд шилжүүлсэн бол байгууллагын гэрээн дээрх үеийн хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг зөвхөн байгууллагын албан бичгийн дагуу гаргаж өгнө.

5.10.4 Дугаарыг гэрээ шилжүүлэн авсан тохиолдолд гэрээ шилжүүлснээс өмнөх саруудын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг гэрээний өмнөх эзэмшигчид гаргаж өгнө.

ЗУРГАА. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

6.1 Хэрэглэгчийн хүсэлтээр гэрээ цуцлах

6.1.1 Хэрэглэгч гэрээ цуцлах тухай саналыг үйлчилгээ үзүүлэгчид ажлын 1 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.

6.1.2 Гэрээ цуцлах сарын багцын хураамжийг бүтэн нэхэмжлэн дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.

6.1.3 Хэрэглэгч гэрээ цуцлах өдрийг хүртэлх ашигласан үйлчилгээний төлөгдөөгүй бүх төлбөрийг төлж барагдуулна.

6.1.4 Гэрээ цуцлах өдөр гэж тухайн сарын билл бодох мөчлөгийн сүүлийн өдрийг хэлнэ.

6.1.5 Гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан Миний моби багцын хэрэглэгч хугацаанаасаа өмнө гэрээг цуцлах болон дахин гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авах тохиолдолд гар утасны үндсэн үнийг төлж барагдуулна.

6.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гэрээг цуцлах

6.2.1 Төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийн дугаарыг 3 сар хадгалан (төлбөрөөс хаагдсан сар тооцогдохгүй) 4 дэх сарын нэгэнд цуцална.

6.2.2 Дугаар хадгалуулах үйлчилгээ авсан хэрэглэгч 2.2.3-т заасан хугацаанд төлбөрийн үлдэгдлээ барагдуулаагүй бол дугаар автоматаар нээгдэх сард нь цуцална.

6.2.3 Хэрэглэгч дараа төлбөрт Миний моби багцын хэрэглээний эрхүүдийг “Зүй зохисгүй хэрэглээ” хийж ашигласан тохиолдолд үйлчилгээг хааж, гэрээ цуцлан, гарсан хохирлыг хэрэглэгчээр төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

6.2.4 Дундаж хэрэглээг Мобиком цаг тухайд нь шинэчлэн тогтоох эрхтэй байна.

mobicom

1. Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл

ХАВСРАЛТ 1

Шинэ хэрэглэгч	
Багцын сарын хураамж	Хэрэглээ хязгаарлах төвшин
14’900₮ - 19’800₮	40’000₮
24’800₮ - 39’800₮	60’000₮
43’800₮ - 59’900₮	80’000₮
69’800₮ - 84’800₮	110’000₮
ОУ-н эрхтэй дугаар	200’000₮

2. Үйлчилгээний үнэ тариф	МИНИЙ МОБИ БАГЦ							
	Ярианы эрх		Дата эрх					
	Сүлжээндээ	Бүх сүлжээнд	5GB	10GB	20GB	30GB	40GB	60GB
2.1 Үндсэн үнэ								
Бүртгэлийн хураамж	10’000₮							
Багцын сарын хураамж	9’900₮	24’900₮	9’900₮	14’900₮	24’900₮	33’900₮	44’900₮	59’900₮
Хэрэглээ хийгээгүй сарын хураамж	9’900₮							
Үндсэн барьцаа	20’000₮ /Багцын сарын хураамжийн нийлбэр дүн 40’000₮-с доош/							
	40’000₮ /Багцын сарын хураамжийн нийлбэр дүн 40’000₮-с дээш/							
Улс хоорондын ярианы эрх	Үндсэн барьцаа + 200’000₮							
Олон улсын роуминг ярианы эрх	Үндсэн барьцаа + 500’000₮							
2.2 Багцад дагалдах хэрэглээний эрх								
Мобикомын сүлжээнд ярих	Хязгааргүй	Хязгааргүй	-					
Бусад үүрэн болон суурин холбооны сүлжээнд	–		-					
Дата эрх	Хэрэглээ хязгааргүй /дата задгай хэрэглээ 128kbps хурдны хязгаартай/		Хэрэглээ хязгааргүй /харгалзах хэрэглээний эрхээс илүү гарсан интернэт хэрэглээ 128kbps хурдны хязгаартай/					
2.3 Ярианы тариф (1 минутаар)								
Мобикомын сүлжээнд	0₮	0₮	50₮					
Бусад үүрэн болон суурин холбооны сүлжээнд	70₮		70₮					
Мобикомын сүлжээнд видео дуудлага хийх	100₮							
Мобикомын улс хоорондын ярианы гарц	Улс хоорондын HiCall 003 гарцын ярианы тариф							
Олон улсын роуминг яриа	Олон улсын роумингийн ярианы тариф							
Бусад операторын улс хоорондын яриа	Бусад сүлжээ рүү ярих ярианы тариф + Тухайн гарцын ярианы тариф							
2.4 Мессэжний тариф (1 мессэж)								
Мобикомын сүлжээнд	19₮							
Бусад үүрэн холбооны сүлжээнд	20₮							
Улс хоорондын мессэж	110₮ - 265₮							
Олон улсын роуминг мессэж	Олон улсын роуминг мессэжний тариф							
2.5 Задгай дата тариф								
Дата, килобайтаар	0₮ (хурд 128kbps)							
2.6 Нэмэлт үйлчилгээний тариф								
HiTone контент татаж авах	Тухайн контентын тариф							
Мессэж дээр суурилсан нэмэлт үйлчилгээ	Тухайн нэмэлт үйлчилгээний тариф							
Дуудлага шилжүүлэх, 6 дуудлага зэрэг авах	Мобикомын сүлжээнд ярих ярианы тариф							
2.7 Нэмэлт үйлчилгээний сарын хураамж								
Видео дата багц	14’900₮							
Энтертаймент дата багц	9’900₮							
Бүх сүлжээнд мессэж бичих эрх	9’900₮							
Сүлжээндээ мессэж бичих эрх	4’900₮							
Дугаар нууцлах (clir) / HiTone	1’200₮							
Дуудлага хадгалах	1’200₮							
2.8 Захиалгат үйлчилгээний төлбөр								
Багц солих / Дугаар солих	0₮							
Дугаар хадгалах	1 сарын 5'000₮							
Гэрээ шилжүүлэх, дугаар бүрт	3’000₮							
Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт	1 сарын 1’000₮							
Сим карт сэргээх, дугаар бүрт	3’000₮ (жилд 1 удаа үнэгүй)							
2.9 WE үйлчилгээ								
Сар бүр авто цэнэглэгдэх 5GB дата багц	5’000₮ (сарын хураамж)							
Нэмэлт 5GB дата багц	5’000₮							
Автоматаар нэгж цэнэглэх үйлчилгээ	Цэнэглэсэн нэгжийн дүн							

Бүх үнэ тарифт НӨАТ тооцогдсон.